

## Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар

### ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**Аудитын код: ДГА-2018/01/СТА-ТЕЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа  
Утас: 7052-2734 Цахим хаяг: [ariunaa.ch@audit.gov.mn](mailto:ariunaa.ch@audit.gov.mn)

Аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020 Цахим хаяг: [lundegmaa.ts@audit.gov.mn](mailto:lundegmaa.ts@audit.gov.mn)

2018 оны 4 дүгээр сарын 20

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	2-3
2	Аудитын тайлан .....	4-15
2.1	Оршил .....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	6
2.5	Дотоод хяналт .....	7
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	11
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	11
2.9.1	Орон нутгийн хөрөнгийн зардлын талаар .....	11
2.9.2	Орон нутгийн нөөц хөрөнгийн талаар .....	12
2.9.3	Орон нутгийн хөгжлийн сангийн талаар .....	123
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	13
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	14
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	14
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: .....	15
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	15
3	Менежментийн захидал .....	16-19
3.1	Орон нутгийн хөрөнгийн зардлын талаар .....	17
3.2	Орон нутгийн нөөц хөрөнгийн талаар .....	18
3.3	Орон нутгийн хөгжлийн сангийн талаар .....	19
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	20-33
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	20
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	22
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	26
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	27
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	31

## 1 Аудитын гэрчилгээ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2018-07-20 № 1-6/422  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Т.ЭНХТҮВШИН ТАНАА

#### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дорноговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн зөв, бодитой шударга илэрхийлсэн байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Аудитын гол асуудал**

Төсвийг төлөвлөхдөө хөрөнгийн зардлыг буруу төлөвлөн зарцуулсан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад иргэдийн санал аваагүй ажлыг баталж санхүүжүүлсэн, Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулах журмыг зөрчиж байгаа зэрэг материаллаг бус хэмжээтэй зөрчил илэрсэн байна. Зөрчлийг аудитын тайлангийн 2.9-д дэлгэрэнгүй дурдсан.

#### **Үүрэг, хариуцлага**

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн (ТЕЗ)-ийн төсвийн багцын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн 15 дугаар зүйлийн 15.1.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 02-ноос 2018 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөж, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Л.Аваадорж, аудитор О.Нарангарав, У.Оюунтүлхүүр нар хариуцан гүйцэтгэв.

Аймгийн ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн Засаг даргын 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 1/618 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т *“аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч мөн”* гэж заасан байна.

Мөн хуулийн 26.2, 26.3-т зааснаар аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн олонхийн саналыг авснаар аймгийн Засаг даргыг Монгол Улсын Ерөнхий сайд 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн Хурлын болон Ерөнхий сайдын өмнө ажлаа хариуцахаар тусгасан байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1-т *“аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ төлөвлөлт, төсөв, санхүү, бүртгэл тооцооны талаар дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”* гэж заасан. Үүнд:

29.1.1. а/нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

Аймгийн Засаг дарга хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд ажлын албатай байх бөгөөд үүнийг аймгийн Засаг даргын тамгын газар эрхлэн явуулна. Аймгийн Засаг дарга нь нэг орлогчтой, ЗДТГазар нь цэргийн штаб болон хариуцсан чиглэл бүхий хэлтсүүдтэй байна. Мөн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт аудитын алба, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар зэрэг байгууллагууд ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17-д зааснаар *“аймгийн Засаг дарга нь тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч байна”* гэж тодорхойлсон бөгөөд мөн хуулийн 14.3-т *“төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”* гэж заасан байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлд аймаг, нийслэлийн Засаг даргын орон нутгийн төсвийн талаарх бүрэн эрхийг тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т “аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

58.2.1.аймгийн удирдлагыг хэрэгжүүлэх;

58.2.2.хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох;

58.2.3.орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;

58.2.4.нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах;

58.2.5.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх;

58.2.6.жигжиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

58.2.8.аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;

58.2.9.малын тэжээлийн нөөц бүрдүүлэх;

58.2.10.усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, орон сууц, нийтийн аж ахуй, үерийн хамгаалалтыг зохион байгуулах;

58.2.11.нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх;

58.2.12.мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;

58.2.13.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх;

58.2.14.аймгийн доторх болон сум хоорондын авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох;

58.2.15.аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах;

58.2.16.аймгийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

58.2.17.хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж баримтжуулсан.

## **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна ТЕЗ-ийн зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 10 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 20 горим, сорил гүйцэтгэв.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аймгийн ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр шинэчлэн боловсруулж баталсан байна. Уг баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна. Гэвч дараах асуудлыг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, хүүгийн орлогыг бүртгэх дансны бичилт,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын санхүүжилтийн илүү, дутуу болон өглөг, авлагыг данс бүртгэлд хэрхэн тусгах асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашигласан байна.

## **2.5 Дотоод хяналт**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аймгийн ТЕЗ-ийн төсвийн багцын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.



Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр 2017 онд дараах ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын “Төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай” 02 тоот албан даалгавар гарган бүх шатны төсвийн захирагч нарт хүргүүлж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, урсгал зардлыг боломжит хэмжээгээр хэмнэж, өр үүсгэхгүй байх, шинэ жил баяр ёслолтой холбоотой зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх зэрэг чиглэлийг онцгойлон анхааруулж ажилласан.
- 2017 оны 02 дугаар сараас Төрийн сангийн дотоод хяналтын мэргэжилтнийг томилон ажиллуулж эхэлсэн бөгөөд аймгийн Засаг даргын А/700 дугаар захирамжаар баталсан удирдамжийн дагуу 2017 оны 11-р сард Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнүүдээс бүрдсэн баг 14 суманд ажиллан төрийн сангийн дотоод хяналт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, анхан шатны бүртгэл хөтлөлттэй танилцан, хүнсний материалын түүвэрчилсэн тооллого хийж, илэрсэн зөрчил дутагдлын мөрөөр заавар зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажиллажээ.

Аймгийн Засаг даргын харьяанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба байгуулагдан дотоод аудитын үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2017 онд нийт 63 байгууллагад төлөвлөгөөт шалгалт, аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Халамжийн сан, Даланжаргалан сумын ЕБС, Замын-Үүд сумын 2-р сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Иххэт сумын ИТХ, ЗДТГ, Засаг даргын нөөц сан зэрэг 8 байгууллагад төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалт, Сайншанд сумын 2 цэцэрлэгт дотоод аудитыг хийж, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг албан тоотоор хүргүүлсэн байна.

Мөн Сангийн яамны нэгдсэн удирдамжаар 5 байгууллага, 2 сангийн 2015-2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэжээ. Тайлант онд хийсэн хяналт шалгалтын явцад нийт 568.2 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, холбогдох байгууллагуудад хугацаатай акт, албан шаардлага өгч, 887 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна.

## **2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Дорноговь аймгийн 2017 оны орон нутгийн төсвийг аймгийн ИТХ-ын 2016 оны 12-р сарын 05-ны 3/055 тогтоолоор баталсан байна. Улмаар 2017 оны 6 болон 12 дугаар саруудад аймаг, сумын ИТХ-аар төсвийг 2 удаа тодотгосон байна.

2017 оны төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төг)

Ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
орон нутгийн төсөвт байгууллага	23,613.7	23,190.2	423.5
сангууд	4,266.9	3,106.7	1,160.2
тусгай шилжүүлэг	29,245.2	29,101.6	143.6
нийт дүн	57,125.8	55,398.5	1,727.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй тоон мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нийт 57,125.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 55,398.5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсөв 1,727.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Зардлын хэмнэлт нь сум хөгжүүлэх сан, нөхөн сэргээлтийн сан зэрэг сангуудын төлөвлөгөөг өндөр төлөвлөснөөс голлон шалтгаалжээ. Мөн орон нутгийн төсвийн байгууллагуудаас аймгийн Засаг дарга, ЗДТГ, Сайншанд, Замын-Үүд сум, аймгийн Байгаль орчны газрын төсөв 390.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь бас нөлөөлсөн.

Төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зарлагын ангилал тус бүрээр аудит хийсэн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд урсгал зардал 1,355.1 сая төгрөг буюу 2.8 хувиар, бараа, ажил үйлчилгээний зардал 1,307.3 сая төгрөг буюу 3.4 хувиар, урсгал шилжүүлэг 47.8 сая төгрөг буюу 0.6 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

Бараа, ажил үйлчилгээний зардал нийт дүнгээрээ хэмнэгдсэн боловч **бүлгийн дүнгээр** эд хогшил, урсгал засварын зардал 1.5 сая төгрөг буюу 0.1 хувиар хэтэрчээ. Үүнд бүлгийн зардал дотроо урсгал засварын зардал 7.4 сая төгрөг буюу 0.7 хувиар хэтэрсэн нь нөлөөлсөн байна.

Бусад зардлууд бүлгийн дүнгээр хэтрээгүй боловч бүлэг дотроо хэтэрсэн зардлуудыг хүснэгтэд харуулав.

Бүлэг дотроо хэтэрсэн зардлууд /сая төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт	Хувь
Үндсэн цалин	16,856.5	16,973.1	116.6	0.7
Тэтгэврийн даатгал	1,521.5	1,687.1	165.6	10.9
Цэвэр, бохир ус	342.0	356.9	14.9	4.3
Бичиг хэрэг	117.3	123.3	6.0	5.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлс	516.7	521.6	4.9	0.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	166.3	168.4	2.1	1.3
Тээврийн хэрэгслийн татвар	11.4	12.3	0.9	7.7
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,137.1	5,145.1	8.0	0.1

Аймгийн Засаг даргын зарцуулах төсвийн хүрээнд сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмжид 179.5 сая

төгрөг баталсан ба гүйцэтгэлээр 185.8 сая төгрөгийн тэтгэмж олгож, батлагдсан төсвийг 6.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Дорноговь аймгийн ТЭЗ-ийн төсвийн үндсэн тэнцэл 2,059.9 сая төгрөгийн ашигтай байхаар үүнээс Төсвийн тухай хуулийн 56.2.1-т заасны дагуу 60 хувийг орон нутгийн төсөвт үлдээх, 40 хувь буюу 824.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр Сангийн яамнаас төсвийг хянаж ирүүлжээ.

Аймаг сумын ИТХ-аар орон нутгийн төсвийг тодотгож, үндсэн тэнцлийг 824.0 сая төгрөгийн ашигтай байхаар баталсан байна.

Аймгийн төсвийн 2017 оны үндсэн тэнцэл /сая төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Суурь орлого	24,301.6	24,219.2
Суурь зарлага	23,477.6	23,054.1
Үндсэн тэнцэл /ашиг/	824.0	1,165.1
Үүнээс:		
Улсын төсөвт төвлөрүүлэх	824.0	600.0

Төсвийн гүйцэтгэлээр үндсэн тэнцэл 1165.1 сая төгрөгийн ашигтай гарсан бөгөөд улсын төсөвт 600.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Шилэн дансны мэдээлэлд нийт 149 удаа мэдээлэл байршуулж мэдээлсэн байна.

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 73 мэдээлэл, бусад 37 мэдээлэл
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 39 удаа мэдээлэл байршуулсан.
  - 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягтай холбоотой 10,566,3 сая төгрөгийн 456 мэдээлэл байршуулахаас сар бүр өссөн дүнгээр давхардуулан нийт 1557 мэдээлэлийг байршуулсан байна.
  - Тендер худалдан авалттай холбоотой 34 ажилд тендер зарласан байх бөгөөд мэдээллийг шалгарсан болон шалгараагүй оролцогчийг тухай бүр мэдээлж байсан байна

Мөн [www.dornogovi.gov.mn](http://www.dornogovi.gov.mn) цахим хуудсанд “шилэн данс” цэсээр дамжуулан шилэн дансны цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна. Үүнд:

1. Төсөв, гүйцэтгэл
2. Хөрөнгө оруулалт
3. Тендер, худалдан авалт
4. Тушаал шийдвэр

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны 3-р улирлын байдлаар нийцлийн аудит хийхэд ТЕЗ-тай холбоотой зөрчил дутагдал илрээгүй.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 20 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Орон нутгийн төсвийн хөрөнгийн зардлын талаар

Аймаг, сумын ИТХ-аар Сангийн яамны хянаж ирүүлсэн төсвийн суурь орлогыг нийт 9,441.1 сая төгрөг буюу 63.5 хувиар, суурь зарлагыг нийт 10,677.1 сая төгрөг буюу 83.4 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна. Үндсэн тэнцлийн ашиг 823.9 сая төгрөгийг СЯ-ны төлөвлөсөн дүнгээр улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцжээ.

Дорноговь аймгийн 2017 оны төсвийн төлөвлөгөө (сая төг)

Үзүүлэлт	Сангийн яам хянасан	Аймаг, сумын ИТХ тодотгосон	Зөрүү
Суурь орлого:	14,860.5	24,301.6	9,441.1
Суурь зарлага:	12,800.6	23,477.7	10,677.1
Үүнээс Урсгал зардал	12,800.6	17,294.2	4,493.6
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>0.0</b>	<b>6,183.5</b>	<b>6,183.5</b>
Үндсэн тэнцэл /ашиг/	2,059.9	823.9	-1,236.0
Орон нутгийн төсөвт үлдэх	1,236.0	0.0	-1,236.0
Улсын төсөвт төвлөрүүлэх	823.9	823.9	0.0

Аймгийн ИТХ-аар хөрөнгийн зардалд 6,183.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн ба үүнээс замын санд 597.5 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтад 5,586.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн хөрөнгийн зардлыг Төсвийн тухай хуульд тодорхойлоогүй “орон нутгийн хөрөнгө оруулалт” гэх нэр томъёогоор нэрлэн аймгийн хэмжээний бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын шинж чанартай зардалд зарцуулжээ.

“Орон нутгийн хөрөнгө оруулалт”-ын зардлууд нь нийтийн эзэмшлийн орон сууцны засвар, зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг, ус дулааны шугамын шинэчлэл, барилга барих, автозам засах, зураг төсөв боловсруулах зэрэгт зарцуулагдсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт нэрээр хийгдсэн ажлууд нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.2 - 58.2.16-д заасан **орон нутгийн хөгжлийн сангийн**

**хөрөнгөөр** хэрэгжүүлж буй чиг үүргүүдтэй давхардаж байна. *Тухайлбал их засвар, автозам, барилга барих, дэд бүтэц, гэрэлтүүлэг, тохижилтын ажил г.м*

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн иргэдээс авсан саналын жагсаалтад буй 2,160.9 сая төгрөгийн ажлыг “орон нутгийн хөрөнгө оруулалт”-ын данснаас санхүүжүүлсэн нь дээрх чиг үүргүүд давхардаж буйг харуулж байна.

Мөн нэг ажлыг орон нутгийн хөрөнгө оруулалт болон хөгжлийн сангийн санхүүжилтээр санхүүжүүлсэн. Энэ нь Эрдэнэ сумын ААНБ, айл өрхийг нэгдсэн шугамд холбох ажилд орон нутгийн хөрөнгө оруулалтаас 213.0 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 77.0 сая төгрөг олгосон.

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 1.2.1, 1.2.3, 6.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1-т заасан аймгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардлыг өөр чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн зардлыг зөвхөн ТЕЗ-ийн шууд харьяанд байгаа орон нутгийн төсөвт байгууллагуудын албан контор барих, их засвар, тээврийн хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж худалдан авах зэрэгт зориулалтын дагуу зөв төлөвлөн зарцуулах, орон нутгийн хөрөнгө оруулалт гэж нэрлэсэн ажлуудыг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх тухай зөвлөмж хүргүүлэх.

## **2.9.2 Орон нутгийн нөөц хөрөнгийн талаар**

Аймгийн ЗДТГ-ын 2017 оны төсөвт “орон нутгийн нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар 700.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, Засаг даргын захирамжаар 692.9 сая төгрөгийг зарцуулжээ. Аймгийн ЗДТГ-ын нөөц хөрөнгийн зарцуулалтыг авч үзвэл төсөвт байгууллагуудад 155.8 сая төгрөгийн хөрөнгийн дэмжлэг олгожээ.

Мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд “бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар 410.3 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс зарцуулахаар төсөв батлуулж, байгууллагуудад хөрөнгө худалдан авахад дэмжлэг үзүүлэх голдуу зориулалтаар 360.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө(чөлөөт үлдэгдэл)-ийн зарцуулалтыг ангилбал 68.0 сая төгрөгийг автомашин худалдан авахад, 62.1 сая төгрөгийг тавилга тоног төхөөрөмж худалдан авахад, 136.6 сая төгрөгийг тохижилт засварын ажилд, урсгал зардалд 94.3 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудад дэмжлэг нэрээр олгосон байна.

Нөөц хөрөнгийг хөрөнгийн зардалд зарцуулж зориулалтын бусаар, үр ашиггүй зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “**ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах**” гэсэн заалтыг зөрчиж байна.

Мөн аймгийн ИТХурал “орон нутгийн нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар 104.0 сая төгрөгийг **бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр хураамж** гэсэн зардлын ангилалд батлуулж зарцуулсан байна.

Аймгийн ИТХурлын төсвийн захирагч **нөөц хөрөнгийн зориулалтаар** хөрөнгө зарцуулж байгаа нь Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр

тогтоолоор “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг үр ашигтай, хууль журмын дагуу төлөвлөж зарцуулах талаар зөвлөмж хүргүүлэх

### 2.9.3 Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2016 онд сумдад хүргүүлэн түүний дагуу иргэдээс саналыг авч, аймгийн ИТХ-ын 3 удаагийн тогтоолоор хөрөнгө оруулалтын ажлуудыг баталсан байна.

Гэвч иргэдээс авсан санал асуулгын жагсаалтад ороогүй “Эрдэнэ сумын төвийн ААНБ, айл өрхүүдийг нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугамд холбох” ажлыг аймгийн ИТХ-ын 86.5 сая төгрөгөөр батлан, гүйцэтгэлээр нийт 77.0 сая төгрөгийн санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон байна.

Энэ нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 60.3.6-д “ОНХСангийн хөрөнгийг орон нутгийн иргэдийн саналыг аваагүй ... зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэхэд баг хорооны иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээнд санхүүжилтийг олгож байх зөвлөмж хүргүүлэх.

### 2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ (ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ)

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөнд тусгасан ажлыг өөр данснаас гарган санхүүжүүлсэн байна. Үүнд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөнд урсгал зардлаар батлагдсан 136.1 сая төгрөгийг “орон нутгийн хөрөнгө оруулалт”-ын данснаас гарган аймгийн ХХААГ-т шилжүүлсэн.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 сарын тодотголоор Эрдэнэ сумын ЦДАШ-ийн 135.0 сая төгрөгийн, Дэлгэрэх сумын ЗДТГ-т автомашин худалдан авах 30.0 сая төгрөгийн ажлуудыг хийхээр нэмж баталсан ба тухайн ажлууд 100% хэрэгжиж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Гэтэл аймгийн ИТХ-ын 2017 оны 12-р сарын тодотголоор дээрх 2 ажлын төсвийг хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтаас хасч баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын тодотголоор Сайншанд сумын нийтийн орон сууцнуудын засварын ажил 720,0 сая төгрөг, 4, 5-р багийн байрны засварын ажил 140.0 сая төгрөгийн нийт 860.0 сая төгрөгийн ажлын төсвүүдийг нэгтгэн 770.0 сая төгрөгийн төсөвтэйгээр баталсан байна. Дээрх 2 ажлын төсөв нийт 90.0 сая төгрөгөөр буурч батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр нийт 828.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгогдсон байна. Санхүүжилтийг тодотголоос өмнө олгосон байсан тул

дээрх 2 ажлын санхүүжилт 12-р сарын тодотгосон төсвөөс 58.1 сая төгрөгөөр хэтэрсэн харагдаж байна.

## **2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД**

УИХ-ын Төсвийн байнгын хороо, ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитаар илэрсэн зөрчлүүдийг дахин шалгана. Зөвлөмжийн хэрэгжилтэд анхаарал хандуулж давтан шалгах нь зүйтэй.

## **2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 541.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Эдгээр зөрчилд холбогдох зөвлөмжүүдийг хүргүүллээ.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар 2018 оны 1-р улиралд өөрийн аудиторуд болон хувийн хэвшлийн аудиторудтай хамтран аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн 82 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийсэн. Эдгээрээс 69 байгууллагад зөрчилгүй дүгнэлт, Айраг, Алтанширээ, Иххэт, Замын-Үүд, Өргөн сумын цэцэрлэг, Хатанбулаг сумын ЭМТ, Сайншанд сумын 4-р сургууль, Замын-Үүд сумын 1-р сургууль, Даланжаргалан, Хатанбулаг, Зүүнбаян багийн Соёлын төв зэрэг 13 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн болно.

Мөн 14 сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, Замын-Үүд сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, бусад сумдад зөрчилгүй дүгнэлт өгсөн.

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 6,518.4 сая төгрөгийн 377 зөрчил илрүүлж, 1,337.0 сая төгрөгийн 154 төрлийн алдааг санхүүгийн тайланд залруулж, үлдэх 5,181.4 сая төгрөгийн зөрчилд 33.7 сая төгрөгийн акт, 293.3 сая төгрөгийн албан шаардлага, 4,854.4 сая төгрөгийн дүнтэй зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

## **2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 4 зөвлөмж, Санхүү төрийн сангийн хэлтсийн даргад 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг аймгийн Засаг даргын 2017 оны 1/2208 тоот албан бичгээр ирүүлжээ. Нийт 7 зөвлөмжөөс 5 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнө оны аудитаас хэрэгжээгүй байгаа зөвлөмжүүд:

- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор арилжааны банкинд байршуулсан 60.0 сая төгрөг, 2000 онд улсын төсвөөс авч сумдад дамжуулан зээлдүүлсэн өвс тэжээлийн авлага 23.2 сая төгрөг, хандивын сан нэртэй дансны эзэн холбогдогч тодорхойгүй 21.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, авлагыг барагдуулах арга хэмжээ авах
- Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг давхар батлуулан зарцуулж байгаа зөрчлийг арилгах

Зөвлөмжийн биелэлтийг ирүүлэхдээ авлагыг барагдуулах зөвлөмжийн талаар судалж байгаа гэсэн ба нөөц хөрөнгийн талаар дахин зөвлөмж хүргүүлсэн.

## **2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгов.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн 127,434.8 сая төгрөг бөгөөд түүний 0.5 хувь буюу 637.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

## **2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн төсвийн багцын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд холбогдох зөвлөмжүүдийг 3.Менежментийн захидал хэсэгт харуулсан.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

---

Төрийн аудитын газар нь аудитын төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь ТЕЗ-ийн төсвийн багцын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Санхүү төрийн сангийн хэлтсийн ажилтнууд болон бусад холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.**

**3.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН  
ЗАРДЛЫН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**Ажиглалт**

Аймгийн ИТХ-аар **хөрөнгийн зардалд** 6,183.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн ба үүнээс замын санд 597.5 сая төгрөг, **орон нутгийн хөрөнгө оруулалтад** 5,586.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн хөрөнгийн зардлыг Төсвийн тухай хуульд тодорхойлоогүй “орон нутгийн хөрөнгө оруулалт” гэх нэр томъёогоор нэрлэн аймгийн хэмжээний бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын шинж чанартай зардалд зарцуулжээ.

“Орон нутгийн хөрөнгө оруулалт”-ын зардлууд нь нийтийн эзэмшлийн орон сууцны засвар, зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг, ус дулааны шугамын шинэчлэл, барилга барих, автозам засах, зураг төсөв боловсруулах зэрэгт зарцуулагдсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт нэрээр хийгдсэн ажлууд нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.2 - 58.2.16-д заасан **орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр** хэрэгжүүлж буй чиг үүргүүдтэй давхардаж байна. *Тухайлбал их засвар, автозам, барилга барих, дэд бүтэц, гэрэлтүүлэг, тохижилтын ажил г.м*

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн иргэдээс авсан саналын жагсаалтад буй 2,160.9 сая төгрөгийн ажлыг “орон нутгийн хөрөнгө оруулалт”-ын данснаас санхүүжүүлсэн нь дээрх чиг үүргүүд давхардаж буйг харуулж байна.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 1.2.1, 1.2.3, 6.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1-т заасан аймгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардлыг өөр чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

**Зөвлөмж**

Хөрөнгийн зардлыг Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалын 1.2.3, 6.1 дэх заалтын дагуу ТЭЗ-ийн харьяа төсөвт байгууллагуудын албан контор барих, их засвар хийх, тээврийн хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж худалдан авах зэрэгт зарцуулах

Орон нутгийн хөрөнгө оруулалт гэж нэрлэсэн ажлуудыг “**аймгийн орон нутгийн хөгжлийн сан**”-гийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар хөгжлийн сангаас санхүүжүүлэх

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4-т “татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон **зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр**” гэсэн заалтын дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн санд аймгийн төсвөөс хөрөнгө оруулах замаар хөрөнгө оруулалтын ажлуудаа санхүүжүүлэх

### 3.2 Орон нутгийн нөөц хөрөнгийн талаар

### Тэргүүлэх ач холбогдол №1

#### Ажиглалт

Аймгийн ЗДТГ-ын 2017 оны төсөвт “орон нутгийн нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар 700.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, Засаг даргын захирамжаар 692.9 сая төгрөгийг зарцуулжээ. Мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд “бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар 410.3 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс зарцуулахаар батлуулсан.

Бусад ангилагдаагүй нөөц хөрөнгийн зарцуулалтыг ангилбал 68.0 сая төгрөгийг автомашин худалдан авахад, 62.1 сая төгрөгийг тавилга тоног төхөөрөмж худалдан авахад, 136.6 сая төгрөгийг тохижилт засварын ажилд, урсгал зардалд 94.3 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудад дэмжлэг нэрээр олгосон байна.

Мөн аймгийн ИТХурал “орон нутгийн нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар 104.0 сая төгрөгийг **бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр хураамж** гэсэн зардлын ангилалд батлуулж зарцуулсан байна.

Аймгийн ИТХурлын төсвийн захирагч **нөөц хөрөнгийн зориулалтаар** хөрөнгө зарцуулж байгаа нь Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тогтоолоор “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг зөрчиж байна.

#### Эрсдэлүүд

Дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд: **Үнэн зөв байдал** - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

#### Зөвлөмж

Засаг даргын нөөц хөрөнгийг Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1-2.3-т заасан зориулалтын дагуу зарцуулах буюу хөрөнгө худалдан авахад зарцуулахгүй байх

Нөөц хөрөнгө нэрээр зарцуулж буй хөрөнгийн эх үүсвэрүүдийг бүгдийг нэгтгэн хууль журамд нийцүүлэх

#### Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

**3.3 Орон нутгийн хөгжлийн сангийн үйл  
ажиллагааны талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**ҮАГ-ын ажиглалт**

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2016 онд сумдад хүргүүлэн түүний дагуу иргэдээс саналыг авч, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 3 удаагийн тогтоолоор хөрөнгө оруулалтын ажлыг баталсан байна.

Гэвч уг батлагдсан тогтоолуудад иргэдийн санал асуулгад ороогүй “Эрдэнэ сумын төвийн ААНБ, айл өрхүүдийг нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугамд холбох” ажлыг батлан, гүйцэтгэлээр нийт 77.0 сая төгрөгийн санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон байна.

Энэ нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 60.3.6-д “**орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно**” гэж заалттай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

**Үнэн зөв байдал** - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

**ҮАГ-ын зөвлөмж**

Орон нутгийн төсөв дэх иргэдийн оролцоог хангаж ажиллах, иргэдийн санал аваагүй ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөнд тусгахгүй байх

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг өөр данснаас санхүүжүүлэхгүй байх

**Төсвийн захирагчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

## 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,402,076,055.51</b>	<b>18,559,642,794.60</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,988,347,530.36</b>	<b>2,793,002,187.72</b>
<b>31100</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>5,030,071.77</b>	<b>10,516,493.49</b>
31110	Төгрөг	5,030,071.77	10,516,493.49
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,983,317,458.59</b>	<b>2,782,485,694.23</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>1,983,317,458.59</b>	<b>2,782,485,694.23</b>
31211	Төрийн сангийн харилцах	1,527,621,644.87	1,926,688,822.61
31213	Арилжааны банк дахь харилцах	455,265,970.20	849,359,445.88
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	429,843.52	6,437,425.74
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>6,896,534,428.33</b>	<b>5,849,913,769.20</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	29,631,132.61	73,710,306.54
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,324,061.28	3,512,061.28
33400	Зээлийн хүүгийн авлага	0	228,850.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	1,190,449,346.73	1,424,093,491.76
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	68,545,441.61	6,754,741.40
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>1,855,389,576.00</b>	<b>479,579,793.74</b>
33510	Байгууллагаас авах авлага	1,818,556,178.50	443,957,572.85
33520	Хувь хүмүүсээс авах авлага	36,833,397.50	35,622,220.89
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>3,747,194,870.10</b>	<b>3,862,034,524.48</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>3,747,194,870.10</b>	<b>3,862,034,524.48</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	3,687,194,870.10	3,802,034,524.48
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	60,000,000.00	60,000,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>116,656,896.10</b>	<b>3,862,054,486.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	95,000,000.00	3,854,618,586.00
<b>34710</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>21,656,896.10</b>	<b>7,435,900.00</b>
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	4,936,896.10	515,900.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	16,720,000.00	6,920,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>5,392,642,420.72</b>	<b>6,023,517,771.68</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>558,332,817.49</b>	<b>689,554,547.99</b>
